




2024 12-р сар

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГААНЫ АЛБА

Шинэ жил хаяанд ойртсон энэхүү торгон агшинд Макро эдийн засгийн 12-р сарын тоймоор 2024 оноо үдэцгээе.

ТӨСВИЙН ТӨСӨЛ ХОРИГИЙН ДАРАА ШИНЭЧЛЭГДЭН БАТЛАГДЛАА.

- 2025 оны төсвийн төсөл 11-р сард 1.9 их наяд төгрөгийн алдагдалтайгаар УИХ-аар орж батлагдаад байсан ч ерөнхийлөгчийн хоригийн улмаас ахин хэлэлцүүлэгдэж 12 сарын 12-нд алдагдалгүй хэлбэрээр батлагдлаа. Ингэхдээ анхны төсвийн төслөөс орлого 395 тэрбум төгрөгөөр, зардал 2.3 их наяд төгрөгөөр буурчээ.
- Зардлын таналтыг бүрэлдэхүүн хэсгээр нь харвал урсгал зардал 726 тэрбум, харин хөрөнгийн зардал 1.5 их наяд төгрөгөөр буурч ирэх жил 2024 оны төсөвлөлтөөс урсгал зардал 2.7 их наяд, харин хөрөнгийн зардал ердөө 300 тэрбум төгрөгөөр өсөх хүлээлттэй байна.
- Ийнхүү 2025 онд төсвийн тэнцвэржүүлсэн орлого, зардал тус бүр 33.5 их наяд төгрөгт хүрэхээр төсөвлөгдөв. Хэдий төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл ирэх онд алдагдалгүй батлагдсан ч түүхий эдийн үнэ сангийн яамны хүлээлтэд хүрэхгүй тохиолдолд экспортын орлого багасах, улмаар төсвийн орлогод нөлөөлж тэнцэл алдагдалд хүрэх төвөгтэй байдал үүсэх эрсдэлтэй байна. /Монголбанкны ерөнхийлөгч, Б.Лхагвасүрэн/

ИНФЛЯЦ 12 САРЫН ДАРАА МОНГОЛБАНКНЫ ЗОРИЛТОТ ТҮВШНЭЭС ДАВАВ.

- 11-р сарын байдлаар инфляц 8.1 хувьтай гарснаар Монголбанкны зорилтот $6+/-2$ түвшнийг давлаа. Улмаар 12-р сарын Мөнгөний бодлогын хорооны шийдвэрээр инфляц хөөрөгдөх эрсдэлийг харгалзан үзэж бодлогын хүүг 10 хувьд хэвээр үлдээх, мөн төгрөг болон валютын заавал байлгах нөөцийн хэмжээг 1 нэгж хувиар тус тус нэмэгдүүлэх шийдвэр гаргалаа.
- Ирэх саруудад геополитикийн нөхцөл байдлаас шалтгаалсан тодорхой бус байдал үргэлжлэх төлөвтэй, мөн цахилгааны үнийн өсөлт, төрийн нийтлэг үйлчилгээ, түрээс, импортын барааны үнийн өсөлт хүлээлтээс өндөр байсан зэрэг хүчин зүйлс дээр үндэслэн ийнхүү бодлогын арга хэмжээнүүдийг авчээ.

1072 ХУВЬЦААНЫ НОГДОЛ АШИГ 350 ОРЧИМ МЯНГАН ТӨГРӨГ ГУРАВ ХУВААГДАЖ ТАРААГДАНА.

- “Эрдэнэс Тавантолгой” компани 2024 онд 4.3 их наяд төгрөгийн ашигтай ажилласнаар 1072 хувьцаа эзэмшигч иргэн бүрд 350 орчим мянган төгрөгийн ногдол ашиг тараагдах хүлээлттэй байгаа бөгөөд эхний ээлжид 135 мянган төгрөгийн олголт 12-р сарын 21-нээс иргэдийн дансанд шилжиж эхэлсэн. Цаашлаад 2025 оны 1,2 дугаар сард ногдол ашиг олгогдоод явах юм. /Л.Оюун-Эрдэнэ, 2024.12.21/
- Улмаар 2022 онд 104 мянган төгрөг, 2023 онд 256 мянган төгрөг тараасан бол, 2024 онд ийнхүү татварын дараа 338 мянган төгрөг тараах хүлээлттэй байна. Мөн Баялгийн сан /Чингис сан/-ийн хуультай холбоотойгоор төрийн өмчит компанийн АМНАТ-ын орлогыг хуримтлуулж хуримтлалын сангийн дансанд байршуулсан мөнгөн хөрөнгийг Монгол Улсын иргэн бүрийн хуримтлалын нэрийн дансанд бүртгээд явж байгаа. Үүнтэй холбоотойгоор эхний ээлжид хуримтлалын санд хуримтлагдаж байгаа хуримтлалтай ижил дүнгээр буюу 135 мянган төгрөгөөр ногдол ашиг тараах болжээ. /Л.Оюун-Эрдэнэ, 2024.12.21/

ИМПОРТЫН ӨСӨЛТ ЭКСПОРТЫН ӨСӨЛТИЙГ ДАВЖ ХУДАЛДААНЫ АШИГ ӨМНӨ ОНЫ МӨН ҮЕЭС 26 ХУВИАР БУУРЧЭЭ.

- Эхний 11 сарын байдлаар нийт экспорт 14.6 тэрбум ам.доллар, нийт импорт 10.6 тэрбум ам.доллартой гарснаар худалдааны тэнцэл 4.0 тэрбум ам.долларын ашигтай гарсан хэдий ч өмнө оны мөн үеэс 26 хувиар буурчээ. Нүүрсний экспортын биет хэмжээ 74 сая тонн-д хүрснээр өмнө оны мөн үеэс 24 хувиар өссөн ч хилийн үнэ буурсан хэвээр байгаа бөгөөд 11-р сард тонн тутамд 92 ам.доллар болж буурсан байна. /2023 оны 11-р сард хилийн үнэ тонн тутамд 115 ам.доллартой байв/
- Харин импортын хувьд дийлэнх хэсгийг хөрөнгө оруулалтын импортын өсөлт буюу автомашин, барилгын материалын өсөлт бий болгожээ. 11-р сарын байдлаар нийт 116 мянган суудлын автомашин импортолсон нь өмнө оноос даруй 42 мянгаар өндөр байна.

ИМПОРТЫН ӨСӨЛТӨӨР ВАЛЮТЫН ГАРАХ УРСГАЛ НЭМЭГДЭЖ УРСГАЛ ДАНС 1.5 ТЭРБУМ АМ.ДОЛЛАРЫН АЛДАГДАЛТАЙ БАЙНА.

- 2024 оны дунд үеэс импортын өсөлт эрчимжсэнээр төлбөрийн тэнцэл ахин алдагдалтай гарч эхэлсэн бөгөөд 10-р сарын байдлаар 257 сая ам.доллартой байна. Харин төлбөрийн тэнцлийн томоохон хэсгийг бүрдүүлэгч урсгал данс 1.5 тэрбум ам.долларын алдагдалтай гарсан байна.
- Улмаар валютын нөөц 2024 оны дунд үе 5.2 тэрбум ам.долларт хэлбэлзэж байсан бол 11-р сарын байдлаар 4.97 тэрбум ам.долларт хүрсэн байна. Улмаар оны туршид тогтвортой байсан төгрөгийн ханш өмнө оны мөн үеэс 15 төгрөгөөр суларч 11-р сарын эцэст нэг ам.долларт 3,417.8 төгрөг ногдож байна.
- Импортын өсөлтөөр урсгал дансны алдагдал өндөр байгаа хэдий ч санхүүгийн дансаар дамжин валютын орох урсгал өндөр байна. Тухайлбал 2024 оны эцэст 800 сая орчим бондын санхүүжилт гадаадын зах зээлд босгож чадсанаар төлбөр тэнцэл ашигтай гарах, нөөцийн хэмжээ 5 тэрбум ам.долларыг давах хүлээлттэй байгаа юм.

ХИЛ ДАМНАСАН ТӨМӨР ЗАМ БАРИХ ТӨСӨЛ БАТЛАГДСАНААР ХЯТАД МОНГОЛЫГ ХОЛБОСОН ХОЁР ДАХЬ ГҮҮР БИЙ БОЛОХ БОЛОМЖ БҮРДЭНЭ.

- Засгийн газар Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийн төслийг 12-р сарын 25-нд УИХ-д өргөн барилаа. Ингэснээр 14 жил гацаад байгаа төмөр замын хил холболтоо хийх боломж бүрдээд байгаа юм.
- Улмаар тээврийн зардал буурах, нүүрсний экспортын биет хэмжээ ихсэх ба өнөөдрийг хүртэл манай улс Тавантолгойн уурхайгаас Гашуунсухайт боомт руу нүүрсээ авто замаар тээвэрлэж нэг тонн нүүрсийг 40 орчим ам.долларын өртгөөр тээвэрлэж байжээ. Харин нүүрсний экспортын хувьд Гашуунсухайт, Шивээхүрэн, Ханги, Бичигт зэрэг боомтуудаар жилд 85 сая тонн нүүрс тээвэрлэх хүчин чадалт байсан бол тээвэрлэх хүчин чадал хоёр дахин нэмэгдэж жилдээ 165 сая тонн нүүрс тээвэрлэх боломж бүрдэх юм.

УТАА БОЛОН ЦАХИЛГААНЫ ХОМСДОЛЫН АСУУДАЛ ХУРЦДАЖ ЕРӨНХИЙЛӨГЧ МЭДЭГДЭЛ ХИЙВ.

- Утааны асуудал, жагсаалтай холбоотойгоор Ерөнхийлөгч У.Хүрэлсүх 2024.12.16-ны өдөр УИХ-ын дарга, Ерөнхий сайд, УИХ дахь намын бүлгийн дарга нар, хотын удирдлагууд, агаарын бохирдлыг бууруулах ажлын хэсгийн ахлагч нар, холбогдох яам тамгын газрын хүмүүсийг дуудан уулзжээ. Уулзалтын дараа хотын дарга анхан шатны арга хэмжээнүүд танилцуулсан ба эхний ээлжид 28 тэрбум төгрөгийн тендер зарлаж гэр хорооллын 32,000 айлд, ногоон хөгжлийн зээлийн нөхцөлөөр зуух тараахаар болж байгааг мэдэгдэв.
- Мөн түүнчлэн утааг бууруулах хүрээнд 2025.1-р сараас сэлбэ дэд төвийн 12,000 айлын орон сууц барих тендерийг 6-10 хувааж зарлах, сайжруулсан түлшний найрлагыг олон улсад шинжлүүлэх, нүүрсэн яндангүй автомашиныг журамлах, Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хороог сэргээн байгуулах зэрэг ажлуудыг дурдав.
- Харин цахилгаан, эрчим хүчний хомсдолыг шийдэх хүрээнд нийт 35 эх үүсвэрийн төсөл хэрэгжиж байгаа ба Улаанбаатар хотын дулаан хангамжийг сайжруулахаар дулааны 3-р станцын суурь дээр 300Мвт цахилгаан, 395Мвт дулааны станцыг ОХУ-тай хамтран зээлээр санхүүжүүлж хийх төлөвлөгөөтэй байгаа юм.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХУУЛЬ ШИНЭЭР ТАНИЛЦУУЛАГДАЖ БАЙГАА БА УРАНЫ ТӨСЛИЙН ТАЛААР МЭДЭГДЭЛ ХИЙГДЭВ.

- Ураны төслийн хувьд засгийн газрын эзэмших 34 хувийн 10 хувь нь алтан хувьцаа, харин 24 хувь нь хуримтлалын санд иргэдийн хадгаламж хэлбэрээр очиход АМНАТ нь орох байдлаар тооцох аргачлал руу орж байгаа талаар ерөнхий сайд мэдэгдээд буй...
- Мөн хөрөнгө оруулалтын тухай хууль ахин шинэчлэгдсэн хувилбараар орж ирж байгаа ба онцлох заалтуудад гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль гэж нэр томьёо өөрчлөгдсөн, мөн үнийн босго заагаагүй, газар ашиглах, эрх олгохтой холбоотой заалтууд бүгд салбарын хуулиудаар зохицуулагдах тухай дэлгэрэнгүй тусгаж өгчээ.


ХУРААНГУЙ

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	НЭГЖ	ТАЙЛАНТ ХУГАЦАА	ӨМНӨХ ҮЕ	ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕ	ЖИЛИЙН ӨСӨЛТ
УЛИРЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2024Q3	2024Q2	2023Q3	
Бодит ДНБ	тэрбум төгрөг	22,828	14,407	21,751	5.0%
Ажилгүйдлийн түвшин	%	6.1	5.8	5.3	15.1%
Дундаж нэрлэсэн цалин	мянган төгрөг	2480	2465	2009	23.4%
Гадаад өр	сая ам.доллар	35,639	34,867	33,246	7.2%
САРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2024M11	2024M10	2023M11	
Гадаад худалдааны үзүүлэлтүүд					
Нийт экспорт	сая ам доллар	14,596	13,207	13,811	5.7%
Зэс	сая ам доллар	2,937	2,617	2,409	21.9%
Нүүрс	сая ам доллар	8,053	7,307	7,931	1.5%
Нийт импорт	сая ам доллар	10,567	9,580	8,373	26.2%
Хэрэглээ	сая ам доллар	3,213	2,891	2,442	31.6%
Аж үйлдвэрийн орц	сая ам доллар	860	788	776	10.8%
Хөрөнгө оруулалт	сая ам доллар	4,540	4,107	3,474	30.7%
Шатахуун	сая ам доллар	1,939	1,780	1,665	16.5%
Тэнцэл	сая ам доллар	4,029	3,627	5,437	-25.9%
Дэлхийн түүхий эдийн үнэ					
Зэс	\$/тонн	9075.7	9534.0	8189.6	14.0%
Нүүрс	\$/тонн	150.6	153.2	132.1	10.8%
Газрын тос	\$/баррель	73.5	75.3	82.2	-10.6%
Алт	\$/трой унц	2652.2	2689.1	1985.8	33.6%
Улсын нэгдсэн төсөв					
Төсвийн тэнцэл	тэрбум төгрөг	1,373	1,523	1,947	-29.5%
Төсвийн орлого	тэрбум төгрөг	26,077	23,867	20,699	26.0%
Төсвийн зардал	тэрбум төгрөг	24,704	22,344	18,752	31.7%

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	НЭГЖ	ТАЙЛАНТ ХУГАЦАА	ӨМНӨХ ҮЕ	ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕ	ЖИЛИЙН ӨСӨЛТ
САРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2024M11	2024M10	2023M11	
Мөнгөний бодлого					
M2 нийлүүлэлт	тэрбум төгрөг	41,507	42,164	35,402	17.2%
ХҮИ (C2020)	индекс	150.1	147.6	138.9	8.1%
Бодлогын хүү	%	10.00%	10.00%	13.00%	-23.1%
Хүү ба ханш					
Ам долларын ханш (Эцсийн)	Төгрөг/\$	3,418	3,405	3,433	-0.4%
Төгрөгийн хадгаламж	%	12.99%	12.27%	11.78%	10.3%
Валютын хадгаламж	%	3.34%	5.06%	4.27%	-21.8%
Төгрөгийн зээл	%	17.00%	17.03%	16.62%	2.3%
Валютын зээл	%	10.18%	9.11%	11.73%	-13.2%
Гадаад валютын нөөц					
Нийт	сая ам доллар	4,964	4,701	4,299	15.5%

БОДИТ ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

■ Бодит ДНБ-ий өсөлт (C2015)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

АЖИЛГҮЙДЭЛ БА ЦАЛИН




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ГАДААД ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ




Эх сурвалж: Монголбанк

ДЭЛХИЙН ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭ




Эх сурвалж: ОУВС

УЛСЫН ТӨСВИЙН ТЭНЦЭЛ




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

УЛСЫН ГАДААД ӨР




Эх сурвалж: Монголбанк

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ




Эх сурвалж: Монголбанк

УЛСЫН ИНФЛЯЦ




Эх сурвалж: Монголбанк

ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ




Эх сурвалж: Монголбанк

АМ ДОЛЛАРЫН ХАНШ



Эх сурвалж: Монголбанк

БАНКУУДЫН ДУНДАЖ ХҮҮ



Эх сурвалж: Монголбанк



ЕРӨНХИЙ ЭДИЙН ЗАСАГЧ

Ө. Мөрөн

Цахим хаяг: murun_u@golomtbank.com

ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЭЭЧ

Б. Анунжин

Цахим хаяг: anunjin.ba@golomtbank.com

ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЭЭЧ

О. Номуншүр

Цахим хаяг: nomunshur@golomtbank.com

ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЭЭЧ

С. Цацрал

Цахим хаяг: tsatsral.sa@golomtbank.com

АНХААРУУЛГА

Голомт банкны Эдийн засгийн судалгааны алба нь Монгол улсын макро эдийн засгийг бүхэлд нь хамарч судалдаг билээ. Энэхүү тайлан нь макро эдийн засгийн хамгийн сүүлийн үеийн өгөгдлийг ашигласан болно. Энэхүү тайланд тусгагдсан агуулга, санаа нь Голомт банкны байр суурийг илэрхийлэх албагүй болно. Голомт банкнаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр энэ тайлангийн аль нэг хэсгийг хуулбарлах, системд хадгалах, ямар нэг хэлбэрээр дамжуулах, цахим механик хэлбэрээр хувилах, бичлэг хийхийг хориглоно.